



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2017 оны 07 сарын 04 өдөр

Дугаар А/360

Булган

**Ажлын хэсэг байгуулах, хэлэлцүүлэг
зохион байгуулах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6. /а/ дахь заалт, Монгол Улсын Их Хурлын 2017 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 39 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг олон нийтээр хэлэлцүүлэх ажлын төлөвлөгөө”-г тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн хэлэлцүүлэг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ц.Бат-Өлзий - Аймгийн Засаг даргын орлогч


Гишүүд: Д.Эрдэнэбилэг	-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
П.Хишигдаваа	-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
О.Наранжаргал	-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
Ё.Бямбацэрэн	-Аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч
С.Баясгалан	-Мэргэжлийн хяналтын газрын дарга
П.Дамба	- Ардын Их хурлын депутат асан
Ц.Дагвадаш	-Төр, захиргааны байгууллагын ахмад ажилтан
Б.Ууганбаяр	-Хялганат тосгоны захирагч
Бүх сумдын Засаг дарга нар	

Нарийн бичгийн дарга: С.Амар -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн

2. Монгол улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн хэлэлцүүлэг зохион байгуулж, гарсан санал дүгнэлтийг нэгтгэн боловсруулж, Улсын Их хурлын ажлын хэсэгт хүргүүлэхийг ажлын хэсгийн ахлагч /Ц.Бат-Өлзий/-д даалгасугай.

3. Хэлэлцүүлгийг сумандаа зохион байгуулж, иргэдийн гаргасан саналыг нэгтгэн аймгийн ажлын хэсэгт 2017 оны 08 дугаар сарын 20-ны дотор ирүүлэхийг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



З.БАТЗОРИГ